



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 0/242

Улаанбаатар хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/21, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 45, 46 дугаар тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020 оны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Багахангай мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ-ын менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтад оролцох этгээдийн хүсэлтийг хянах, менежментийн гэрээний төсөлд ирүүлсэн саналыг хүлээн авч, шинэчилсэн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Уралдаант шалгаруулалтад оролцох этгээдийн хүсэлтийг хянах, менежментийн гэрээний төсөлд ирүүлсэн саналыг хүлээн авч шинэчилсэн төслийг боловсруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050000613

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны .06. сарын 04. –ний өдрийн  
0242 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Дарга	Д.Төмөрбаатар	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч дарга
Гишүүд	Д.Итгэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга
	С.Пүрэвсүрэн	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	М.Мандах	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Ч.Мөнхбаяр	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн